



Australian Government
Department of Immigration
and Border Protection

Оюутны хялбаршуулсан визний журам

Оюутнуудад зориулсан ерөнхий мэдээлэл

2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн Австрали Улс оюутны виз олгох журамд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа бөгөөд үүний нэг хэсэг нь оюутны хялбаршуулсан визний журам юм. (ОХВЖ).

ОХВЖ-ны хүрээнд дараах өөрчлөлт орсон болно. Үүнд:

- Бүх гадаад оюутнууд сонгосон сургалтын чиглэлээс үл хамааран нэг ангиллын оюутны виз (ангилал 500) мэдүүлэх;
- Бүх гадаад оюутнууд оюутны визийг цахим хэлбэрээр (интернэтээр) мэдүүлэх;
- оюутны визний мэдүүлэгт хавсаргах англи хэлний түвшин болон санхүүгийн чадавхийг нотлох нотлогоо гаргах асуудлыг Цагаачлалын эрсдэлийн удирдлагын шинэ журмаар зохицуулна.

Австрали Улсын Засгийн газар эдгээр өөрчлөлтийг хийх болсон шалтгаан

ОХВЖ нь оюутнуудад чиглэл өгч оюутны визийг үнэн бодитоор мэдүүлэх ажиллагааг энгийн, хялбар болгон улмаар, цагаачлалын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн арга замыг нэвтрүүлж, байгууллагын шийдвэр гаргах шат дарааллыг багасгаснаар Австрали Улсын олон улсын боловсролын салбарын тогтвортой өсөлтийг дэмжих зорилготой юм.

Оюутны визний Ангилал 500-д тавигдах үндсэн шалгуурууд

Үнэн бодит, түр хугацааны оршин суугч (ҮБТХОС байх)

ҮБТХОС-дад тавигдах шаардлага оюутны виз мэдүүлэгч бүх хүнд хамаарах бөгөөд тухайн хувь хүний нөхцөл байдал нь Австрали Улсад түр хугацаагаар оршин суух зорилготойг нотолж байгааг эсэхийг харгалзан үзсэний нь Үнэн бодит, түр хугацааны оршин суугч мөн эсэхийг тухайн оюутны цагаачлалын түүх, эх орондоо буцах зорилго, нөхцөл байдал эсвэл Австрали Улсад үлдэх зорилго, нөхцөл байдал зэрэг хувь хүний хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж үнэлдэг.

Итгэмжлэгдсэн сургалтад бүртгүүлсэн байх

Гадаад оюутнууд итгэмжлэгдсэн сургалтад бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд оюутны визний мэдүүлэг гаргахдаа хүлээн зөвшөөрсөн сургуулиас олгосон Элсэлтийн батламжийг хавсаргана.

Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яамны тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцах оюутнууд (Гадаад харилцааны яам болон Батлан хамгаалах яамнаас гаргасан бичиг); дунд сургуулийн солилцооны сурагчид (дунд сургуулийн солилцооны сурагчдын зөвшөөрлийн мэдэгдлийн маягтуудыг хавсаргана. Судалгааны ажлын зорилгоор Австралид үлдэн магистр, докторын зэрэг хамгаалах оюутнуудад энэхүү шаардлага хамаарахгүй.

Санхүүгийн чадавхи болон англи хэлний түвшин

Гадаад оюутнууд Австрали Улсад суралцах хугацаанд шаардагдах сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг даах хангалттай хөрөнгийн эх үүсвэртэй байх шаардлагатай. Оюутны визтэй хүн Австралид тодорхой цагийн хязгаартай ажил эрхлэх боломжтой боловч сургалтын төлбөр болон амьжиргааны зардлаа ажил эрхэлж олно гэж найдаж болохгүй. .

Виз мэдүүлэх явцад Цагаачлалын алба оюутнуудаас санхүүгийн чадавхи болон англи хэлний түвшинг нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж болно. Тухайн оюутны иргэний харьяалал болон суралцах гэж буй боловсролын байгууллагатай холбоотой цагаачлалын асуудлаар гарах эрсдэлийн үр дүнг харгалзан үзснийг үндсэн дээр виз олгоно

Цагаачлалын албаны үйлчлүүлэгчдэд зориулсан онлайн үйлчилгээний хэсэгт заасны дагуу виз мэдүүлэгч визний мэдүүлгийг явуулахаас өмнө санхүүгийн болон англи хэлний чадавхийг нотлох баримтыг хавсаргасан байх шаардлагатай. . Дээрх баримт бичгийг хавсаргаагүй тохиолдолд виз олгохоос татгалзах үндэслэл болно.

Санхүүгийн чадавхи болон англи хэлний мэдлэгийг түвшинд тавигдах шаардлагатай холбоотой мэдээлэл авахыг хүсвэл *Санхүүгийн чадавхи* болон *Англи хэлний түвшинд тавих шаардлагууд гэсэн* танилцуулах хуудаснаас үзнэ үү.

Эрүүл мэнд базан байдал

Гадаад оюутнуудад зан байдлын хувьд тогтвортой байх шаардлага тавьдаг. ш Оюутны виз мэдүүлэх явцад эрүүл мэндийн үзлэгт хамрагдах бөгөөд оюутны виз олгохоос өмнө Гадаад оюутны эрүүл мэндийн даатгал (ГОЭМД) хийлгэсэн байх шаардлагатай.

Оюутны визний мэдүүлэг

Оюутны визнийг (ангилал 500) онлайн буюу цахим хэлбэрээр мэдүүлнэ. Энэ талаарх нэмэлт мэдээллийг www.border.gov.au/Trav/Stud.

хаягаар орж үзнэ үү:

Оюутны визний мэдүүлгийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа

Цагаачлалын алба бүрэн бүрдүүлсэн оюутны визний мэдүүлгийн 75 хувийг визний мэдүүлэг бүрдүүлж хүргүүлснээс хойш нэг сарын дотор эцэслэн шийдвэрлэх зорилго тавин ажиллаж байна.

Визний мэдүүлгийг хянан шийдвэрлэх хугацааг багасгахын тулд оюутны визний мэдүүлэгт шаардлагатай бүх баримт бичгийг хавсаргасан байна. . Шаардлагатай бүх баримт бичгийг хавсаргаагүй тохиолдолд визний мэдүүлгийг хянан шийдвэрлэх хугацаа алдах болон виз олгохоос татгалзах үндэслэл болно.

Оюутны ангиллын визтэй хүмүүст ОХВЖ-ын үзүүлэх нөлөө

ОХВЖ нь зөвхөн 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс хойш гаргасан оюутны визний мэдүүлэгт хамаарах бөгөөд үүнээс өмнө нь олгосон оюутны ангиллын визтэй хүмүүст нөлөөлөхгүй

Одоогоор 570–576 ангиллын оюутны визтэй хүмүүсийн гэр бүлийн гишүүд оюутны виз аваагүй бөгөөд цаашид Австрали Улсад байгаа буй гэр бүлийн гишүүдтэйгээ нэгдэх гэж байгаа бол 500 ангиллын виз мэдүүлнэ.

Их дээд сургууль төгссөний дараах түр виз (ангилал 485)

Их дээд сургууль төгссөний дараах түр виз (ангилал 485) мэдүүлэх шалгуур өөрчлөгдөхгүй. *Их дээд сургууль төгссөний дараах түр визний (ангилал 485)* талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.border.gov.au/about/corporate/information/fact-sheets/45temp-graduate485 цахим хаягаас авах боломжтой.